


МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
НОМЫН САН

ШИНЭ НОМЫН МЭДЭЭ
2021 №01
(2021.01.01-04.01)



Эмхэтгэсэн: Номзүйч С.Найгалмаа

Н.Энхтуяа

Улаанбаатар хот
2021 он

ГАРЧИГ

ФИЗИК-МАТЕМАТИКИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	1
БИОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	2
ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	2-9
ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	9-11
УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	11-13
ТӨР ЭРХ, ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ УХААН.....	13-17
ЦЭРГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	17-18
БОЛОВСРОЛ, СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ УХААН.....	18
СЭТГҮҮЛ ЗҮЙ.....	19
ХЭЛ БИЧГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	19-20
УРАН ЗОХИОЛ.....	21-25
УРЛАГ. УРЛАГ СУДЛАЛ.....	25-26
ГҮН УХААН.....	26-27
СЭТГЭЛ СУДЛАЛ.....	27-28
НОМ ЗҮЙН ЛАВЛАГААНЫ ГАРЫН АВЛАГА.....	28-29
ГАДААД ХЭЛ ДЭЭРХ НОМ, ЗОХИОЛ.....	30-38

Товчилсон үгийн тайлбар:

БУУТ- Байгалийн ухааны уншлагын танхим /306 тоот/

НХУУТ- Нийгэм, хүмүүнлэгийн ухааны уншлагын танхим- I,II /211, 108 тоот/

ГНОФ- Гэрээр ном олгох фонд-I,II,III /110,201,401 тоот/

ГФ- Гадаад номын фонд /411 тоот/

ЛавФ- Лавлагааны фонд /409 тоот/

ЭШФ- Эрдэм шинжилгээний фонд /411 тоот/

БС- Бизнесийн сургуулийн номын сан /Хич-V 505 тоот/

ХЗС- Хууль зүйн сургуулийн номын сан /Хич-III 205 тоот/

ОУХНУС- Олон улсын харилцаа, Нийтийн удирдлагын

сургуулийн номын сан /Хич-V 304 тоот/

ФИЗИК-МАТЕМАТИКИЙН ШИНЖЛЭХ УХААН

Онолын ба шугаман бус физик, биофизикийн судалгааны өгүүллүүд:

Доктор Д.Баттогтохын бүтээлийн эмхэтгэл / Эмхт. Д.Бүрнээ; Эрхлэн хэвл. Б.Оргил; Хавтасны зур. Д.Болдбаатар; Эх бэлт. Ч.Самбууням; Хавтасны диз. Б.Эрдэнэбулган.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 488х.



Энэ номонд доктор Доржсүрэнгийн Баттогтохын дурсгалд зориулж, түүний физик болон биофизикийн чиглэлээр бие дааж болон бусадтай хамтарч 1995 оноос 2019 оны хооронд бичсэн судалгааны өгүүллүүдийг эмхэтгэн багтаасан байна. Тус эмхэтгэл нь монголын их дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагын оюутан, багш, судлаачдын судалгааны ажлаа хийж гүйцэтгэх, мэдлэгийн хүрээгээ тэлэхэд нь чухал дэм болох бүтээл юм.

22.31+28.071

О-353

ЭШФ Т 24091-24092

Ламжав Д. **Ерөнхий тополог** / Ред. Ж.Даваадулам; Эх бэлт. Ж.Даваадулам.- УБ., 2020.- 393х.- ISBN: 978-9919-20-211-8.



Ерөнхий тополог нь хязгаар, тасралтгүй, орчин, хэмжил зэрэг зөн бодлын ээдрээтэй ойлголтуудыг тайлбарлан тодорхойлж судалдаг математикийн салбар юм. Энэхүү ном нь тополог огторгуй, байгуулах аргууд, компакт огторгуй, жигд тогтоц, функцэн огторгуй, метрчлэх шинжүүд зэрэг сэдвүүдийг хамран онолын өндөр түвшинд энгүүн тодорхой бичигдсэн бүтээл юм.

22.152

Л 203

/БУУТ-7, ГНОФ-14/

ЭШФ 23929-23931

Ердийн дифференциал тэгшитгэл: Инженер, технологийн мэргэжлийн ангийн оюутны гарын авлага / Ред. Ц.Балжинням, Ц.Мөнх-Эрдэнэ, В.Өлзийбаяр ба бус.; Эх бэлт. Ү.Ариунаа, Ц.Балжинням.- УБ.: ШУТИС., 2020.- 233х.- ISBN: 978-9919-22-646-6.



Энэхүү гарын авлагыг ШУТИС-ийн инженерийн ангийн оюутнуудын судалдаг Ердийн дифференциал тэгшитгэл хичээлийн агуулгад тохируулах номнуудаас зарим ойлголтуудыг ишлэн нийт зургаан бүлэгтэй, Практик асуудлыг математикийн бодлого болгон хөрвүүлэх, дифференциал тэгшитгэл хэрхэн үүсч буйг хялбар жишээнүүдээр тайлбарлан бүлэг бүрт оруулсан байна.


22.161.6

Е 62

/БУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т 24209-24211

БИОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААН



Монголын ботаникийн сэтгүүл № 01 / Ерөн. ред. И.Түвшинтогтох; Техник ред. Ж.Түшигмаа, Э.Энхмаа; Нарийн бичгийн дарга О.Энхтуяа; Гишүүд Ч.Дугаржав, Ч.Доржсүрэн, Ш.Цоож ба бус.- УБ.: Бэмби сан, 2019.- 127х.


Тус сэтгүүл нь ургамал судлалын чиглэлийн мэргэжлийн сэтгүүл бөгөөд ургамлын аймаг, ангилалзүй, зураглал, өөрчлөлт, хөдлөлзүй, экологи, ургамлын нөөц судлал, биотехнологи, биохими зэргийг хамрах юм.

Сэтгүүлийн энэхүү дугаараас Монголын мөөгийн аймагт тэргүүлэх дээд мөөгийн овог, төрлүүдийн байрзүйн дараалал тэдгээрийн тархах зүй тогтлын тухай болон Богдхан уулын Манзуширын амны гол горхи, ус намгархаг газрын замгийн бүрэлдэхүүн, Монгол дахь Хумилж (*Alchemilla* L.)-ийн мөн Шүхэртэн овгийн төрөл таних онцлог шинж тэмдэг зэрэг судалгааны үр дүнтэй танилцах боломжтой.

28.5(1)я5

М 692

ЭШФ Т 23892-23893



Хомын тал орчмын шувууд=Birds of khomyn tal / Эмхэтгэж орч. Ц.Мөнхбат, Б.Анударь; Хян. П.Ганхуяг; Хэвлэлийн диз. Ж.Батбаатар.- УБ., 2020.- 298х.

Энэхүү товхимолд энэ нутагт тогтмол суурьшин амьдардаг, дамжин нүүдэллэдэг, нүүдэллэн ирж үрждэг нийт 141 зүйл шувуудыг таних шинж, амьдралын онцлог, хамгааллын статус болон тархацын тухай мэдээллийг гэрэл зургийн хамт орууллаа. Шувуудын олон улс дахь ховордлын зэрэглэлийг Олон Улсын Байгаль Хамгаалах Холбоо (IUCN)-ын зэрэглэлийн шинэчилсэн хувилбараар, бүс нутгийн үнэлгээг Монгол орны шувуудын Улаан данс (2011)-ны ангиллаар тус тус тодорхойлов хэмээжээ.

28.693.35(1)

Х 44

ЭШФ Б 30100-30102

ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН



Бүшиг К. Гурван улсын түүхэн тэмдэглэл I: Шиллагийн уг тэмдэглэл / Орч. Ц.Цэрэндорж; Эх бэлт. Б.Эрдэнэсайхан.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 318х.- ISBN: 978-9919-23-307-5.

Энэ бүтээлд Шилла улсын уг тэмдэглэл буюу тус сурвалжийн эхний 12 дэвтрийг нэгтгэсэн. Энэ сурвалжийг түүх бичлэгийн "тэмдэглэл, шастирын хэлбэрээр зохиосон агаад энэ нь уг тэмдэглэл, илтгэл, ойллого, олон шастир гэсэн 4 үндсэн хэсгээс бүрдэнэ

63.3(5СоӨ)

Б 917

/НХУУТ-5, ГНОФ-8/

ЭШФ Т 24028-24032

Мягмаржав Б. **Олон улсын газрын харилцаа-"Монголын нууц товчоон"-д: "Дэлхий-олон улс-Монгол улс" = International land relations - in Mongolian secret history** Международные земельные отношения в Сокровенном сказании Монголов: Цуврал Б.18(9): Монголын нууц товчооны 780 жилийн ойд зориулав / Ред. М.Халиун; Диз. Э.Доржханд.- УБ.: Соёмбо, 2020.- 296х.- (Монгол улсын засгийн газар. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар).- ISBN: 978-9919-20-243-9.



Энэ бүтээл нь гурван хэсэг, 12 бүлэг, 46 дэд бүлэг, хавсралт бүхий бүтээл юм. Чингис хаан түүнийг залгамжлагчид долоон сая 770 мянган ам дөрвөлжин нутгаар хаяа тэлэн хүн амын дийлэнх төвлөрсөн Хятад, Араб, Европын соёл иргэншилт орнуудыг Монголын эзэнт гүрэнд нэгтгэсэн. Газар эзэмшил нь улсын газар буюу мянгатын нутаг, дархалсан нутаг, соёрхолын газар гэж ангилж байжээ. Эл хаант улсад өрх, эр хүн тутмаас зоос авах, хувь тогтоосон татвар авах зэргээр онцлог байсныг энэ бүтээлээс танин мэдэж болно.

63.3+65.32-5

М 985

/НХУУТ-1/

ЭШФ Т 24010-24012

Равдан Э. **"Монголын нууц товчоон" дахь газар нутгийн нэр судлал:** Дэвт. 1: Түүх, хэл шинжлэлийн нэрзүй, газарзүйн хавсарсан судалгаа / Хян. Д.Төмөртоогоо, Б.Цогтбаатар, Ш.Чоймаа, С.Чулуун; Диз. Б.Бүжидмаа.- УБ.: Мөнхийн үсэг, 2020.- 653х.- ISBN: 978-9919-23-869-4.



Энэхүү номонд МНТ-ны 230-аад оноосон хийгээд дэвсгэр нэрийг түүх, хэл шинжлэлийн нэр зүй, газарзүйн хавсарсан судалгаагаар хийж гүйцэтгэсний дээр Монгол улсын Дундад эртний болон өндөр нарийвчлал бүхий газрын зураг, цахим сүлжээний цөөнгүй газрын зураг, гэрэл зураг нийт 210 орчим цахим мэдээллийн олон сайт, линкийг ашигласан болно.

63.3(1)

Р 131

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Т 23947-23949

Равдан Э. **"Монголын нууц товчоон" дахь газар нутгийн нэр судлал:** Дэвт. 2: Судалгааны сонгомол өгүүллийн эмхэтгэл / Ред. С.Чулуун, Ц.Цэрэндорж; Эмхэтгэн хэвлэлд бэлт. Э.Равдан, Б.Цогтбаатар, Г.Алтансүх.- УБ.: Мөнхийн үсэг, 2020.- 581х.- ISBN: 978-9919-23-869-4.



"Монголын нууц товчоон дахь газар нутгийн нэр судлал" судалгааны сонгомол өгүүллийн эмхэтгэлд "Монголын нууц товчоон"-д бичигдсэн


зарим түүхэн дурсгалт газар нутгийн байршил, түүх, хэл шинжлэлийн нэр зүй, газарзүйн судалгааны чиглэлээр бичсэн гадаад, дотоодын үе үеийн эрдэмтэн судлаачдын 50 гаруй эрдэм шинжилгээний өгүүллийг эмхэтгэн толилуулж байна.

63.3(1)

P 131

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Т 23950-23952



Археологийн судалгаа: Монголчуудын гарал, угсаа-соёлын хөгжил / Ред. А.Очир, Ц.Төрбат; Хэвлэлд бэлт. Ж.Гантулга; Газрын зур. Б.Батдалай.- УБ.: Мөнхийн үсэг, 2020.- 279х.- ISBN: 978-9919-9538-5-0.

Археологийн судалгаа: Монголчуудын гарал, угсаа-соёлын хөгжил хэмээх энэхүү бүтээлд, Монголчуудын гарал, хэл, соёлын үүсэл, Монгол угсаатан үүсч бүрэлдсэн өлгий нутаг, Монголчуудын угсаа - соёлын хөгжлийн талаар шинжлэх ухааны шинэ үзэл баримтлалуудыг дэвшүүлжээ. Бүтээл нь археологич, угсаатны судлаач, түүхч, палеогенетикич, палеоантропологич, хэл шинжээч, түүх, соёл сонирхогч нарт зориулагдав.

63.4(1)

A 779

ЭШФ Т 23901-23902



Археологийн судлал: Б. XXXVIII: Дэвт. 1-11 / Ерөн. ред. Д.Цэвээндорж; Нарийн бичгийн дарга Ц.Төрбат; Эх бэлт. Г.Ангарагдөлгөөн; Редакцийн зөвлөлийн гишүүд Ч.Амартүвшин, Я.Бенмани (ХБНГУ), Вэй Цзян (БНХАУ), Б.Гүнчинсүрэн, А.П.Деревянко (ОХУ), Ч.Ерөөл-Эрдэнэ, И Сон-бук.- УБ., 2019.- 124х.

Энэхүү бүтээлд Хэмцэгийн соёлын хадны зураг (2015 оны өгүүлэл), Монголын баруун хойд бүс нутагт хийсэн хадны зургийн судалгаа, Хүрлийн хожуу үеийн овог аймгуудын соёлын асуудал ба тээгийн хадны зураг, Археологийн дурсгалаас илэрсэн олдворт тулгуурлан монгол нохойн үүлдрийг тодорхойлох нь, Хотгорын руни бичээс, Цагаан туруутын голын хөндийгөөс шинээр илрүүлсэн буган хөшөөд, Хүннүгийн шавар ваарнаас илрүүлсэн тарианы хар будаа "*Panicum miliaceum* L"-ны үлдэгдэл "хэв дардас"-ын судалгаа, Соронзон толгойн монгол булш, Мэлхийн толгойн дурсгалын он цагийн асуудалд, Монголд хорин жил ажилласан олон улсын археологийн экспедицийн талаарх хувийн бодлоос, Польшийн археологичдын Монголд хийсэн судалгаа зэрэг 10 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл багтжээ.

63.4(1)я5

A 779

ЭШФ Т 23903-23904

Монголын эртний хот суурин = Ancient settlement of Mongolia / А.Очир, Э.Уртнасан, С.Энхболд ба бус.; Ерөн. ред. Г.Эрэгзэн, С.Чулуун; Эрхлэн хэвл. Г.Эрэгзэн, Л.Эрдэнэболд; Эх

бэлт. Диз. Г.Ариунболд, Б.Баясгалан; Газрын зур. Б.Батдалай.- УБ., 2020.- 284х.- ISBN: 978-9919-9538-6-7.

Та бүхний гарт хүрч буй "Монголын эртний хот суурингийн дурсгал" хэмээх ном нь цувралын X боть болно. Энэхүү ботид Хүннүгийн эзэнт гүрэн, Уйгур ба Киданы үеийн хот суурингийн талаарх судалгааны үр дүн болон дурсгалуудын гэрэл зураг, олдвор хэрэглэгдэхүүний танилцуулга багтжээ. Уг бүтээл нь Монголын эртний хот суурингийн дурсгалын талаар цэгцтэй, зөв мэдээллийг өгч чадна гэдэгт итгэлтэй байна.

63.4(1)

М 692



ЭШФ Т 23897

Чандмань хар уулын археологийн дурсгал II / Ред. Ч.Амартүвшин.- УБ.: Мөнхийн үсэг, 2020.- 166х.- ISBN: 978-9919-9538-4-3.

Энэ удаа хэвлүүлж буй Чандмань хар уулын археологийн дурсгал - II бүтээл нь тус дурсгалт газарт хийгдсэн малтлага судалгаанаас илэрсэн олдвор эх хэрэглэгдэхүүнд хийгдсэн лабораторийн шинжилгээний үр дүнг голчлон багтаасан гэдгээр онцлогтой. Мөн энэхүү эмхэтгэлд олдвор хэрэглэгдэхүүнийг судлан шинжилсэн Монгол, Япон, Солонгос, Америкийн 17 судлаачийн археологи, угсаатны зүй, материал судлал, палеозоологи, сэргээн засварлалт, эх бичиг судлалын чиглэлээр бичсэн нийт 11 өгүүлэл багтжээ.

63.4(1)

Ч 205



ЭШФ Т 23899-23900

Чихэртийн зоо ба Баянцагааны дурсгал / Ред. С.Чулуун; Гар зур. С.Энхболд, П.Алдармөнх, Б.Лхагвасүрэн ба бус.; Гэрэл зур. Ан Жэпил, И Юнъюн, Пэг Үнги ба бус.- УБ., 2020.- 400х.- ISBN: 978-9919-9538-8-1.

Уг бүтээл нь Монгол - Солонгосын хамтарсан хээрийн судалгааны ангийн Төв аймгийн Баянцагаан сумын нутаг дахь Чихэртийн зоо хэмээх Хүннүгийн цогцолбор дурсгалт газар ажилласан судалгааны үр дүн юм. Археологийн малтлага судалгааны үр дүнд Хүннүгийн язгууртны булшнаас илэрсэн олдворт хийсэн он цаг тогтоох шинжилгээгээр НТӨ II зууны үед хамаарахыг тогтоосон. Мөн тус бүс нутагт өмнө нь огт хайгуул судалгаа хийгдээгүй бөгөөд бид дөрвөн удаа хайгуул хийсний үр дүнд илэрсэн дурсгалуудыг бүртгэн судалгааны эргэлтэд оруулж байна. Энэхүү бүтээл орон нутаг судлал, Монголын эртний түүх судлагч хэн бүхэнд чухал хэрэглэгдэхүүн болох юм.

63.4(1-M14)

Ч 728




ЭШФ Т 23898

Аюуш Ц. Баруун Монголчуудын угсаатны зүйн хэрэглэгдэхүүн: Аман болон гэрэл зургийн эх сурвалж / Ред. На.Сүхбаатар; Диз. Ч.Эрдэнэбат; Хавтасны зураг чимэглэл Ц.Аюуш.- УБ.: Бэмби сан, 2020.- 420х.- (Монгол Улс. Шинжлэх Ухааны Академи. Түүх, Угсаатны Зүйн Хүрээлэн).

63.5(1)

А 968




Б.1.- 420х.- ISBN: 978-9919-23-129-3.

Энэхүү бүтээлд 1977-1978, 1986, 1988 онуудад Увс, Ховд аймгийн дөрвөд, баяд, хотон, өөлд, захчин нарын дунд явуулсан угсаатны зүйн хээрийн судалгааны аман болон гэрэл зургийн эх сурвалжийг анх удаа нэгтгэн оруулсны дээр энд нийтдээ 175 ахмад үеийнхнээс авсан 350 гаруй нүүр хуудас аман эх сурвалж, мөн аймгийн музей, сумдын Орон нутаг судлах кабинет болон хүмүүст хадгалагдаж байсан дөрвөдийн 220 гаруй эд өлгийн биет дурсгалын хар, цагаан гэрэл зураг багтжээ.

/НХУУТ-7/

ЭШФ Т 24063-24065




Б.2.- 372х.- ISBN: 978-9919-23-338-9.

Энэхүү бүтээлд 1989, 2015-2016 онуудад Увс, Ховд аймгийн дөрвөд нарын дунд явуулсан угсаатны зүйн хээрийн судалгааны аман болон гэрэл зургийн эх сурвалжийг анх удаа нэгтгэн оруулсны дээр энд нийтдээ 120 орчим ахмад үеийнхнээс авсан 230 гаруй нүүр хуудас аман эх сурвалж, мөн аймгийн музей, сумдын Орон нутаг судлах кабинетууд болон хүмүүст хадгалагдаж байсан дөрвөдийн 470 гаруй эд өлгийн биет дурсгалын хар-цагаан болон өнгөт гэрэл зураг багтжээ.

/НХУУТ-7/

ЭШФ Т 24066-24068



Аюуш Ц. Халхын угсаатны зүйн хэрэглэгдэхүүн: Аман болон гэрэл зургийн эх сурвалж / Эрхл. С.Чулуун; Хян. Г.Цэрэнханд, У.Булаг; Хавтасны зураг чимэглэл Ц.Аюуш; Диз. Ч.Эрдэнэбат.- УБ.: Бэмби сан, 2020.- 306х.- (Монгол Улс. Шинжлэх Ухааны Академи. Түүх, Угсаатны Зүйн Хүрээлэн).- ISBN: 978-9919-20-008-4.

Энэхүү бүтээлд 1972 онд Увс аймаг, 1973 онд Дорнод аймаг, 1979 онд Өмнөговь аймаг, 1981 онд Хөвсгөл, Булган аймаг, 1982 онд Говь-Алтай, Увс, Архангай, Өвөрхангай аймгийн зарим сумдад суух халхчуудын дунд явуулсан угсаатны зүйн хээрийн судалгааны аман болон гэрэл зургийн эх сурвалжийг нэгтгэн оруулсны дээр номын нэр агуулгаас гажсан нэг зүйл бол Дархад, Тува-уйгар буюу цаатан, мөн Буриад нарт холбогдох зарим хэрэглэгдэхүүний талаар тусгажээ.

63.5(1)

А 968

/НХУУТ-7, ГНОФ-3/

ЭШФ Т 24069-24071

Аюуш Ц. **Дөрвөд**: Түүхэн угсаатны зүйн судалгаа / Ред. На.Сүхбаатар; Диз. Ч.Эрдэнэбат; Хавтасны зураг чимэглэл Ц.Аюуш.- УБ.: Бэмби сан, 2019.- 334х.- ISBN: 978-9919-22-191-1.



Энэхүү бүтээлд Дөрвөдийн түүхэн угсаатны зүйн үндсэн бүх асуудал, сэдвийг хөндсөний дээр 1977-1978, 1986, 1988-1989 онуудад Дөрвөд нарын дунд зохион явуулсан олон удаагийн хээрийн судалгааны аман мэдээ, эх сурвалжийг гол хэрэглэгдэхүүн болгон оруулсны дээр дөрвөд хүн ам 80 орчим мянгад хүрч байгаа бөгөөд Увс аймгийн Давст, Сагил, Түргэн, Бөхмөрөн, Ховд, Өлгий, Өмнөговь, Наранбулаг, Завхан, Тариалан сумдын 1-2 баг, Ховд аймгийн Дөргөн сум бүхлээрээ, мянгад сумын нэг баг, тэрчлэн Баян-Өлгий аймгийн Цагаан нуур тосгоны харъяанд цөөн тоотой дөрвөд айл өрх оршин сууж байгаа талаарх мэдээлэл зэрэг багтжээ.


63.5(1)

A 968

/НХУУТ-7, ГНОФ-3/

ЭШФ Т 24072-24074

Аюуш Ц. **Зүүн болон умард Монголын угсаатны зүйн хэрэглэгдэхүүн**: Аман болон гэрэл зургийн эх сурвалж / Ред. Г.Цэрэнханд, Ж.Баярсайхан; Диз. Ч.Эрдэнэбат; Хавтасны зураг чимэглэл Ц.Аюуш.- УБ.: Бэмби сан, 2020.- 404х.- (ШУА. Түүх, угсаатны зүйн хүрээлэн Монголын үндэсний музей).- ISBN: 978-9919-20-431-0.



Энэхүү бүтээлд 1974, 1976 онуудад Дорнод, Сүхбаатар аймаг, 2003, 2005-2008, 2017-2018 онд хөвсгөл аймгийн зарим сумдад явуулсан угсаатны зүйн хээрийн судалгааны аман болон гэрэл зургийн эх сурвалжийг багтаажээ. Уг бүтээл нь монголын угсаатны зүйн сэдвээр сонирхон судалгаа эхэлж буй дотоод, гадаадын залуу судлаачид, музейн залуу ажилтан нар, тэрчлэн их, дээд сургуулийн оюутнуудад хэрэгцээтэй мэдээлэл өгөх болно.


63.5(1)

A 968

/НХУУТ-7, ГНОФ-3/

ЭШФ Т 24146-24148

Аюуш Ц. **Монголын угсаатны зүйн судалгааны зарим асуудал**: Угсаатан-соёлын ялгаа- уламжлал / Ред. С.Бадамхатан, В.Фицью, Ж.Баярсайхан; Диз. Ч.Эрдэнэбат; Хавтасны зураг чимэглэл Ц.Аюуш.- УБ.: Бэмби сан, 2020.- 311х.- (ШУА. Түүх, Угсаатны Зүйн Хүрээлэн. Монголын үндэсний музей).- ISBN: 978-9919-23-776-9.



Энэхүү бүтээлд Монголын угсаатны зүйн судалгааны зарим асуудлыг хөндөж бичсэн судалгааны өгүүлэл, хурлын илтгэл, угсаатны зүйн тэмдэглэл мөн англи хэлээрх цөөн ажил, тэрчлэн Монголын угсаатны зүй 3 боть хамтын

бүтээлийн тэргүүн ботид хэвлэгдсэн зарим бүтээлийг багтаажээ. Уг бүтээл нь монголын угсаатны зүйн сэдвээр сонирхон судалгаа эхэлж буй дотоод, гадаадын залуу судлаачид, музейн залуу ажилтан нар, тэрчлэн их, дээд сургуулийн оюутнуудад хэрэгцээтэй мэдээлэл өгөх болно.

63.5(1)

A 968

/НХУУТ-7, ГНОФ-3/

ЭШФ Т 24143-24145



Намжил Т. **Монгол өрх гэр бүл: Цуврал бүтээл: 5 боть.-** УБ.: Бит пресс, 2020.- (Монгол Улс. Боловсрол Шинжлэх Ухааны Академи).

Б.І: Эртний үе: Гэр бүл судлал, түүх, угсаатны зүйн судалгаа: / Ред. Н.Бэгз; Диз. Э.Халиунцэцэг.- 200х.- ISBN: 978-99929-59-54-1.

Монгол гэр бүл судлаач Т.Намжил нь өөрийн эрдэм шинжилгээний үнэ цэнэтэй анхдагч бүтээлээ тусгай ном болгон хэвлүүлэн гаргажээ. Тус 1-р ботид монгол гэр бүлийн түүх судлал, монгол, дорно, өрнийн гэр бүлийн зан заншлын уламжлал, холбооны талаар өгүүлжээ.

63.5(1)

H 984

/НХУУТ-5/

ЭШФ Б 30235-30237



Б.ІІ: XII-XIII зуун: Монголын нууц товчоо - Монголчуудын гэр бүлийн түүх, уламжлалын судалгааны үнэт сурвалж болох нь / Ред. Н.Бэгз; Диз. Т.Ууганбаяр.- 2 дахь хэвл.- 176х.- ISBN: 978-99978-67-27-8.

Зохиолч уг ботид “Монголын нууц товчоон”-нд гэр бүл судлалын үүднээс хандан хийсэн судалгаандаа үндэслэн их гэр бүл, овог, ураг барилдахуй, гэрлэлт, гэр бүлтэй холбогдох ёс Их хатдын сурган хүмүүжүүлэх үзэл санаа, хүмүүжлийн гол чиглэл, уламжлал болон Чингис хааны гэр бүлийн харилцааны ур ухаан, ёс жаяг, бэлгэдэл талаас нь авч үзсэн байна.

63.5(1)

H 984

/НХУУТ-5/

ЭШФ Б 30238-30240



Б.ІІІ: Манжийн үе: XVII-XIX зуун / Ред. А.Пунсаг; Диз. Э.Мөнхзул.- 128х.- ISBN: 978-9919-23-215-3.

Энэхүү бүтээлд Манжийн эрхшээлийн үе дэх Монгол өрх гэр бүлийн нөхцөл байдал хүний эрх- аюулгүй орчин, амьдралын баталгаа, амьд байх эрх ноцтой зөрчигдөх болсон, өлсгөлөнд нэрвэгдэн өлбөрч үхэхэд хүрч байсан XVII-XIX зууны үеийн хэцүү бэрх цаг үед монгол гэр бүлийн

дархлаа хэрхэн доройтож байсан талаар түүхэн баримт судалгаанд үндэслэн өгүүлжээ.

63.5(1)

Н 984

/НХУУТ-5/

ЭШФ Б 30241-30243

Б. IV: XX-XXI зууны эхэн / Ред. Х.Баавгай; Диз. Э.Мөнхзул.- 200х.- ISBN: 978-9919-23-214-6.

Энэхүү бүтээлд Монгол өрх гэр бүлийн хөгжлийн шинэ үеийн судлал, Богд хаант Монгол улсын үеийн өрх гэр бүл ба гэр бүлийн эрх ба төрийн бодлого, хүн амын өсөлт, эмэгтэйчүүдийн эрх, хотжилт, соёлын довтолгоо хэмээн хувааж монгол гэр бүлийн өөрчлөлт хөгжлийн түүхийг авч үзсэн байна. Түүнчлэн монгол гэр бүлийн шинэ үеийн өөрчлөлт ба даяаршил, гэр бүлийн харилцаа, сэтгэл зүйн менежментийн талаар өгүүлжээ.

63.5(1)

Н 984

/НХУУТ-5/

ЭШФ Б 30244-30246



Б.V: Монгол өрх гэр бүлийн ёс заншил, сурган хүмүүжил / Ред. Н.Бэгз; Диз. Э.Мөнхзул.- 3 дахь хэвл.- 244х.- ISBN: 978-99929-90-21-X.

Уг бүтээлд Монголчуудын гэр бүлийн сурган хүмүүжлийн уламжлалд тогтолцооны үүднээс судалгаа хийж, түүний мөн чанар, бүтэц байгууламж өвөрмөц асуудлыг илрүүлсний үндсэн дээр гэрийн сурган хүмүүжлийн нэг гол онцлог нь эх эцэг хүүхдээ хянан халамжлах, зориуд биеэр үлгэрлэн сургаж хүмүүжүүлэх, албадан тулгах, аргадан гуйхын аль нь ч биш, аливаа асуудлын мөн чанарыг ухааруулж сургах нь маш зөв авууштай арга барил болох талаар түлхүү өгүүлжээ.

63.5(1)

Н 984

/НХУУТ-5/


ЭШФ Б 30247-30249



ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН

Дорж Т. **Эзэн Чингис хааны удирдахуйн удвис**: Уйгаржин монгол бичгээр / Хян. Эрдэнэтогтох, Хүмүүжилт; Орч. Баянаа.- УБ.: МУИС пресс, 2019.- 244х.- ISBN: 978-99973-49-97-2.

Зохиогч “Монголын нууц товчоо”, “Судрын чуулган”, “Алтан товч” болон бусад түүхийн эх сурвалжуудад тулгуурлан Чингис хааны удирдах удвисын тухай энэ номонд өгүүлжээ. Их эзэн Чингис хааны удирдах удвисыг Чингис хаанд удирдахуйн шинжлэх ухаан бүрэлдэн төлөвшихөд нөлөөлсөн орчин хүчин зүйл, түүний удирдахуйн бодлого, бүтэц, агуулга, Их Монгол улсын төр, түүний үйл ажиллагаа, удирдахуйн мотиваци, манлайлал, дайн байлдааны удирдахуйн урлаг, түүний




удирдах урлаг ба эрин үе, Монголын менежментийн философи загварыг томъёолохуй гэсэн 7 бүлэгт хуваан авч үзжээ.

65.290+63.3(1)

Д 542

/НХУУТ-4, БС-3/

ЭШФ Т 23977-23979



Лувсандамдин В. **All in-Монгол хаадын бизнес загвар** / Ред. В.Энхбат, Э.Алтансүх.- УБ.: Гуравдагч Мянган Сан, 2019.- 362х.- ISBN: 978-9919-22-039-6.

All In гэдэг нь хэн бүхний мэддэгээр покерийн нэр томъёо. Юу ч үлдээлгүй байгаа бүх жетоноо бооцоонд тавьж богино хугацаанд хожлын боломжоо тултал үзэхийг хийх гэдэг. Өнөө цагийн тэрбумтнууд олон улс орны зах зээлийг эзэлж, хэрэглэгчдийг байлдан дагуулсан нууцаа <бизнес загвар> гэсэн агуулгаар томъёолон тайлбарладаг. Монголын их хаадууд өнөөдрийн бидний нийгэмд хүрэлцэн ирсэн бол бидэнд ямар сургаал, зөвөлгөө өгөх байсан бол оо? Эцэг эх нь <том>байсан бол үр хүүхэд нь тэр дайтай байхыг хүсдэг. Эцэг өвгөдийнхөө амжилтыг өнөө цагт давтах тухай бодоход л бид гар мухар, сэтгэлгээ мохоо байдалтай нүүр тулж байна.Бидэнд үүнийг хэрэгжүүлэх технологи, загварчлал нь үгүйлэгдэж буйг тэмдэглэжээ.

65.290-2

Л 819

ЭШФ Б 30218-30219



Нацагдорж Б. **Баялаг бүтээгч Чимиддоржийн Даваабаяр** / Ред. Б.Энх-Амгалан, Л.Жаргалсайхан; Эмхт. Н.Ганболд, С.Уранчимэг.- УБ.: Хөх Монгол принтинг, 2016.- 195х.- ISBN: 978-99973-76-41-1.

Ундрэн оргилох их ажил үйлсийн эзэд “Баялаг бүтээгчдийг дэмжинэ” төслийг санаачлагч Бизнесийн удирдлагын доктор Ч.Даваабаярыг манай эх орны өнцөг булан бүрт жижиг, дунд үйлдвэр эрхлэн хөгжүүлж байгаа баялаг бүтээгч нөхөдтэй нь хамтатган тэдний ажил үйлс, амжилт бүтээл, туршлагын талаар энэхүү номонд өгүүлжээ.

65.9(1)

Н 347

ЭШФ Т 23905

Оюунцэцэг Л. **Үндэсний инновацийн тогтолцоо бүрдүүлэх онол, практикийн асуудлууд: Нэг сэдэвт бүтээл (монограф)** / Ред. Т.Дорж; Техник ред. М.Заяа, М.Бурмаа; Хэвлэлийн эх бэлт. М.Бурмаа, Т.Сүмжидмаа; Хавтасны загвар Б.Мандухай, Д.Бүжин.- УБ., 2019.- 386х.- (ШУТИС. Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль).- ISBN: 978-9919-21-970-3.

Энэхүү бүтээлд инноваци, түүнтэй холбоотой гол ойлголт, категориудын мөн чанар, агуулга, ангилал, инновацийн процесс, үйл ажиллагаа, инновацийн салбар түүний хүрээнд явагдах интеграцын үйл явц тэр дундаа Монгол улсын хувьд дэлхий дахины энэхүү нийтлэг чиг хандлагыг харгалзан хөгжлийнхөө бодлого стратегийн хүрээнд инновацийн чиг баримжааг тусган бодитойгоор хэрэгжүүлэх мөн үндэсний инновацийн тогтолцоо, экосистем бүрдүүлж хөгжүүлэх асуудлыг онол арга зүй болоод практик арга туршлага талаас нь тусгажээ.



65.9(1)

О-634

/НХУУТ-5, БС-2, ОУХНУС-3/

ЭШФ Т 23552-23554

Цэлмэг З., Бямбасүрэн Б. **Бөгтөр ЖДҮ**: Жижиг, дунд үйлдвэрлэл: Авлига-алдагдсан боломж-аж үйлдвэрийн хувьсгал / Ерөн. ред. И.Рэнчинханд; Ред. Б.Норов; Шог зур. С.Цогтбаяр; Эх бэлт. Б.Эрдэнэбилэг.- УБ.: Адмон, 2019.- 308х.- (Баялаг бүтээгч 2).- ISBN: 978-9919-23-186-6.



Монгол улсад шийдвэр гаргагчид нь баялаг бүтээгчдийнхээ боломжийг хулгай хийсэн бодит нөхцөл байдал ба жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хууль бус зарцуулалтыг илрүүлсэн болон хариуцлага тооцох процессийн явц, бодит байдал, ЖДҮ-ийн эрх зүйн орчин, хөгжлийн зураглалын талаар тус номноос танилцах боломжтой.

65.9(1)

Ц 945

/НХУУТ-2/

ЭШФ Т 23906-23907

УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН

Бор Ж. **Монголын дипломат товчоон**. - УБ., 2020.- 400х.

Энэхүү бүтээл он цагийн хувьд Хүн гүрний үеэс аваад Монголын нэгдсэн улсын үе, тусгаар тогтносон Монгол улсын үеийг бүхэлд нь хамрах бөгөөд монголын гадаад харилцаа, гадаад харилцааны ёс журам, уламжлал, дипломат түүхийн асуудлыг цогцоор нь багтаажээ.



66.4(1)

Б 60

/НХУУТ-7/

ЭШФ Б 30169-30171

Баярхүү Д. **Аварзэдээс Бат-Очир хүртэл дипломатчийн эгэл бус замнал** / Ред. Д.Баярхүү; Диз. С.Даш-Очир.- УБ.: Мөнхийн үсэг, 2020.- 408х.- ISBN: 978-9919-23-595-6.



Энэхүү бүтээлд Олон улсын харилцааны судлаач-профессор, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин дипломатч Д.Баярхүүгийн 2013-2018 оны хооронд "Төрийн захиргаа" сэтгүүлийн "Намтар судлал" булан болон дээр дурдсанаар сэтгүүлийн тусгай дугааруудад нийтлүүлсэн арван нэгэн алдартай эрхмүүдийн ажил амьдралын баялаг түүхийг тусгажээ. Тэд бүгд улс орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, аюулгүй байдлыг бэхжүүлэх, Монгол улсын гадаад нэр хүндийг өсгөх, улс хоорондын найрсаг харилцааг хөгжүүлэхийн төлөө хүчин зүтгэж, зарим нь хэлмэгдэж хувь хүнийхээ хувьд амьдралын ээдрээтэй зам туулжээ. Энэ нь хувь хүмүүсийн амьдралын түүх гэхээсээ илүүтэй улс орны тухайн цаг үеийн нөхцөл байдал, төрийн ой санамжийг илэрхийлдэг гэдэг утгаараа сургамжтай бөгөөд нэн ач холбогдолтой бүтээл болж чаджээ.

66.4(1)

Б 381

/НХУУТ-3/

ЭШФ Т 23983-23984



Баярхүү Д. **Оросын геополитикийн фронт холбоотны эрэл** / Ред. С.Баттулга.- УБ.: Удам соёл, 2020.- ISBN: 978-9919-20-038-1.

Энэхүү бүтээлд Оросын геополитик болон хуучин Зөвлөлт холбоот улсын суурин дээр буй болсон тусгаар улсуудын хамтын нөхөрлөлдөө Орос хэн болчихсон, бусад түнш улсуудтайгаа ямар харилцаатай байгаа, Оросын эдийн засаг дэлхийн эдийн засгийн нэг хэсэг, чухал эд эс нь гэдэг талаар хөндсөний дээр Белоруссын одоогийн ерөнхийлөгчийн талаар дурджээ.

66.4(2Орос)

Б 381

Б.1.- 350х.

/ОУХНУС-10/

ЭШФ Б 30163-30165

Б.2.- 398х.

/ОУХНУС-10/

ЭШФ Б 30166-30168



Баттөмөр Б. **Төрийн зохицуулалт** / Эх бэлт. Б.Мөнхдөл.- УБ.: Эрдэнэзул, 2020.- 212х.- ISBN: 978-9919-23-554-3.

Энэхүү бүтээлд зах зээлд шийдэж чадахгүй асуудал гарах бүрт төрийн уян хатан, ухаалаг зохицуулалт шаардлагатай байсныг тэр бүр хэрэгжүүлж чадаагүй ирсний буруу, түүнээс үүсэлтэй гажуудлын горьг бид хангалттай амсч байна. Тиймээс төрийн зохицуулалт ямар үед, яагаад хэрэгтэй болдог, ямар арга хэрэгслээр дамжуулан түүнийг хэрэгжүүлдэг болон чөлөөт зах зээлд төрийн зохицуулалтыг хэрхэн хэрэглэж болох талаар тайлбарлажээ.

66.5(1)

Б 341

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Б 30183-30185

Лейкофф Жорж. **Зааны тухай бүү бод** / Ред. С.Ууганбаяр, Д.Очирмаа; Орч. Г.Сугиррагчаа; Орчуулгын ред. Б.Дөлгөөн; Эх бэлт. Б.Баясгалан.- УБ., 2020.- 205х.- ISBN: 978-99973-1-830-5.



Зааны тухай бүү бод номын бүрэн шинэчилсэн хувилбар анхны хэвлэлийн орхисон тэр газраас цааш үргэлжилж, харах хүрээг тодорхойлохын ач холбогдол, сүүлчийн арван жилд энэ асуудал хэрхэн хувьсаж өөрчлөгдсөн, ертөнцийг үзэх прогрессив, консерватив хоёр үзлийг нэгэн зэрэг дагадаг хүнтэй хэрхэн ярилцах, ухуулга лоозонгийн эсрэг хэрхэн тэмцэх вэ гэх мэт асуудлыг улам гүнзгийрүүлэн судалсан талаараа илүү ойлгомжтой байдлаар тодорхой тусган харуулжээ.

66+67.400.7

Л 32

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Б 30142-30144

ТӨР ЭРХ, ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ УХААН

Захиргааны ерөнхий хуульд холбогдох баримт бичиг- I / Эрхл. Д.Ганзориг, Ц.Цогт, З.Сүхбаатар ба бус.; Хэвлэлд бэлт. Б.Оюунтуул, М.Чимэддолжин.- УБ.: Адмон принт, 2019.- 508х.- ISBN: 978-99978-767-4-4.



Уг бүтээлд 2015 оны 6 дугаар сарын 19-ны өдөр Монгол улсын их хурлаас батлан гаргаж, 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж буй "Захиргааны ерөнхий хууль"-д холбогдох баримт бичгийг Улсын их хурлын тамгын газрын архивт хадгалагдаж байгаа уг эхээр багтаасан бөгөөд та бүхэн эдгээр баримт бичигтэй бүхэлд нь танилцах боломжтой.

67.401

З 327

ХЗС 21809-21811

Монгол улсын төрийн тогтолцооны товч нэгтгэл / Ред. Ц.Амарсанаа; Нэгтгэсэн Э.Тод-Од.- УБ., 2020.- 544х.



Энэхүү эмхтгэл нь хуулийн чиглэлийн оюутнууд, иргэд болон төрийн албан хаагчдад ч хэрэгцээтэй гарын авлага төдийгүй Монгол улсын төрийн байгуулалтын хууль эрх зүйн орчин, бүтцийн талаар тодорхой тусган харуулсны дээр багтсан мэдээллийг Монгол улсын хууль, тогтоомж, холбогдох эрх зүйн акт, холбогдох байгууллагын мэдээлэл дээр үндэслэн гаргасан болно.

67.401(1)

М 692

ХЗС 21735-21749



Цогт Ц. **Захиргааны хэргийн шүүх = Administrative court** / Эх бэлт. М.Билгүүн.- УБ.: МУИС пресс, 2019.- 330х.- ISBN: 978-9919-22-619-0.

2004 оноос захиргааны эрх зүйн чиглэлээр бичсэн өгүүлэл, нийтлэлээ 2016 онд эмхэтгэж гаргасан билээ. Түүнээс хойш шинээр бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, хийсэн судалгаа, үнэлгээ, дүн шинжилгээ зэргийг "Захиргааны хэргийн шүүх" гэсэн нэг сэдвийн хүрээнд багцлан хэвлүүлж Захиргааны хэргийн шүүх байгуулагдсаны 15 жилийн ойд зориулан та

бүхэнд хүргэж байна.

67.401

Ц 756

ХЗС 21607-21608, 21806-21808



Пүрэвбаатар Р. **Япон улсын хэрэглэгчийн гэрээний тухай хууль: Орчуулга, товч тайлбар = Consumer contract act (Japan): Translation and brief commentary:** Хувийн эрх зүйн цуврал / Ред. Б.Ундрах; Эх бэлт. Т.Энхтунгалаг; Хавтасны диз. Ч.Амарзаяа; Орчуулж тайлбар бичсэн Р.Пүрэвбаатар.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 175х.- (МУИС. ХЗС).- ISBN: 978-9919-20-384-9.

Энэхүү бүтээлд хамгийн сүүлд 2018 оны 06 сарын 15 (Хэйсэйгийн 30 он, хууль, Дугаар 54)-ны өдрийн байдлаар орсон нэмэлт, өөрчлөлтийг багтаасан бөгөөд Япон улсын Иргэний хуулийн 2017 оны нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор тус хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийг мөн хамарсан болно.

67.404.2(5Яп)

П 915

/НХУУТ-3, ХЗС-10/

ЭШФ Б 30211-30212



Өршөөлийн хуулиудад хийсэн дүн шинжилгээ: Бодлогын судалгааны тайлан / Багийн ахлагч Ж.Эрдэнэбулган; Судлаачид Ж.Батмөнх, Б.Гончигсумлаа, Д.Ренчиндорж.- УБ.: Би Си Ай, 2019.- 100х.- ISBN: 978-99978-803-7-6.

Уг судалгааны бүтээлд эрүүгийн өршөөл, татварын өршөөлийн асуудлыг боловсронгуй болгох, өршөөлийн үр нөлөө, боловсруулалт, судалгааг сайжруулах гэсэн 3 үндсэн зорилтын хүрээнд авч үзсэний дээр боловсруулсан санал, зөвлөмж нь гагцхүү судалгааны багийн судалгааны

үр дүн, итгэл үнэмшилд тулгуурласан болно.

67.408

Ө 955

ХЗС 21467-21471

Арбитрын сэдэвт эрдэм шинжилгээний нийтлэлийн эмхэтгэл: Арбитр 90 жил / Хян. С.Энхцэцэг; Эмхт. М.Шинэбаяр, Ө.Бат-Эрдэнэ; Эх бэлт. Э.Номинсогоо, О.Эрдэнэдалай; Диз. О.Гомбо-Эрдэнэ.- УБ.: Би Си Ай, 2020.- 408х.- ISBN: 978-9919-20-688-8.



Энэ бүтээлд 2000 оноос хойш нийтлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүллийн тогтмол хэвлэлүүд болон хувийн эрх зүйн сэдэвт эрдэм шинжилгээний хурал, илтгэлийн эмхэтгэл зэрэг багтсан болно.

67.410

A 71

/ХЗС-1/

ЭШФ Т 24089

Арбитр эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл / Ред. Ж.Амарсанаа; Эмхт. А.Доржготов, Т.Мэндсайхан, С.Энхцэцэг; Хэвлэлд бэлт. Ч.Дэлгэрмаа, Ө.Оюун-Эрдэнэ, А.Доржготов; Эх бэлт. Д.Мөнхжаргал.- УБ.: ХЗҮХ-ийн хэвлэх үйлдвэр, 2020.- 357х.- ISBN: 978-9919-9614-3-5.



Энэхүү эмхэтгэлд Монгол улсын эдийн засгийн эрх зүйн суурь зарчим, гэрээний эрх зүйн харилцааны үндсэн агуулгын илэрхийлэл болох Монгол улсын үе үеийн Үндсэн хуулийн заалтуудаас хэсэгчлэн, мөн төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үеийн аж ахуйн байгууллагуудын хоорондын маргааныг улсын арбитр хянан шийдвэрлэх эрх зүйн үндсийг тодорхойлсон хэм хэмжээ, улсын арбитрын байгууллагын тогтолцоог илэрхийлэх холбогдох түүхэн баримт бичгийг эмхэтгэсэн байна.

67.410(1)

A 71

/ХЗС-1/

ЭШФ Т 24088

Доржготов А. ба бус. **Монгол улс дахь арбитрын байгууллага түүхэн товчоон: 1930-2020** / Т.Мэндсайхан, С.Энхцэцэг; Ред. Ж.Амарсанаа; Эх бэлт. Ч.Дэлгэрмаа, Ө.Оюун-Эрдэнэ, Э.Цэлмэг; Диз. О.Гомбо-Эрдэнэ.- УБ.: ВСІ., 2020.- 216х.- (МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитр).- ISBN: 978-9919-20-689-5.



Энэ номонд Монгол Улсад арбитрын байгууллага үүсэж хөгжсөн түүхэн баримт бичигт тулгуурлан түүхэн үйл явдлын товчоог толилуулжээ.

67.410(1)

Д 542

/ХЗС-1/

ЭШФ Т 24087

Баярсайхан Д. **Эрүүгийн процессын эрх зүй:** Ерөнхий анги.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 239х.- ISBN: 978-9919-23-856-8.



Эрүүгийн процессын эрх зүй нь хууль зүйн шинжлэх ухааны мэдлэгийн бие даасан салбар бөгөөд сүүлийн үед эрчимтэй хөгжиж буй эрх зүйн чухал судлагдахуун юм. Энэ бүтээл нь МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Профессорын багаас хэрэгжүүлж буй "Эрүүгийн процессын шинэтгэл" сэдэвт судалгааны төслийн үр дүнд хийгдсэн бөгөөд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн сургалтанд зориулагдсан болно. Уг бүтээлд тухайн шинжлэх ухааны уламжлалт хандлагыг улам баяжуулж, шинэчлэн хөгжүүлэхэд анхаарсан ба эрүүгийн процессын эрх зүйн ерөнхий ангийн суурь ойлголт, зарчим, судлагдахууны үндсэн бүтцийг орчин үеийн мэдлэгийн шинэ арга зүйд тулгуурлан авч үзжээ.

67.411

Б 381

ХЗС 21898-21927



Гадаад орнуудын орон нутгийн эрх зүй: Онол ба орчин үеийн практик / Ред. Д.Мөнхгэрэл, Д.Ганзориг; Орос хэлнээс орч. Г.Цэрэндулам; Эх бэлт. Д.Ганчимэг.- УБ.: Адмон, 2017.- 651х.- ISBN: 978-9919-9618-1-7.

Энэхүү бүтээлд үндсэн хуулийн болон орон нутгийн эрх зүйн шинэ хууль тогтоомжийг судалж, нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны практик, сүүлийн арван жилд зарим улс орнуудын хэрэгжүүлсэн орон нутгийн шинэчлэлийн үндсэн дээр гадаад орнуудын орон нутгийн эрх зүйн институцийн хөгжил, орон нутгийн тогтолцооны онцлогийг нээн илрүүлсний дээр судлаачид орчин үеийн Оросын харьцуулсан эрх зүйн шинжилгээний аргыг хэрэглэжээ. Уг бүтээл нь хууль зүйн чиглэлээр суралцаж буй оюутан, аспирант, багш нар, төрийн болон орон нутгийн албан хаагчид, бүх шатны төлөөллийн байгууллагын депутат нар, түүнчлэн орчин үеийн дэлхийн нийтийн засаглалын асуудлыг сонирхогч нарт зориулав.

67.412

Г 132

ХЗС 21750



Мөнх-Очир Ц. Санхүүгийн гэрээний суурь: Сургалтын гарын авлага.- УБ.: ВСІ., 2019.- 169х.- (Хууль зүй, Дотоод хэргийн яам, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг).- ISBN: 978-9919-21-182-0.

Энэхүү гарын авлага нь "Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах" төслийн үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулж буй "Олон улсын гэрээний эрх зүйн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх онол, практикийн сургалт"-ын материалын эхний хэсэг юм. 2018 оны ээлжит сургалтыг санхүүгийн гэрээ байгуулахад зөвөлгөө өгч буй

хуульч танд зориулан эхэ төрлийн гэрээг байгуулахад анхаарах зүйлс болон гэрээ хэлэлцээрт

ашиглагдаж байгаа санхүүгийн нэр томъёо, аргачлалыг зөв ойлгох, ашиглах талаар шаардлагатай мэдлэгийг олгох чиглэлээр зохион байгуулсан.

67.412.2я7

М 816

ХЗС 21888-21897

Уянга М., Сарантуяа Д. **Олон улсын нийтийн эрх зүйн семинарын хичээлийн гарын авлага:** Бодлого, асуулт.- УБ.: МУИС пресс, 2019.- 96х.- (МУИС-ийн ХЗС).- ISBN: 978-9919-21-508-8.



Энэхүү гарын авлага нь олон улсын эрх зүйн хичээлийг судалж буй оюутнуудад зориулагдсан бөгөөд зарим кейс даалгаврыг гадаадын хуулийн сургуулийн жишиг даалгавар, олон улсын байгууллагын сургалтын материалд үндэслэн боловсруулж, хичээлийн хөтөлбөрт нийцүүлэн бэлтгэжээ.

67.412.1я7

У 711

ХЗС 21339-21353

Монгол улсын шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл: Б.5 / Эмхт. Д.Аюуш, Б.Хонгорзул; Хян. Ц.Мандах.- УБ.: Мөнхийн үсэг, 2020.- 384х.- ISBN: 978-99973-2-866-3.



Энэ удаагийн ботид эрүү, иргэн, захиргааны хэргийн 3 шатны шүүхийн шийдвэрүүдийг тооны хувьд ижил харьцаатай сонгон шалгаруулж, нийслэл болон орон нутгийн шүүхийн шийдвэрүүдийг хамруулж, улсын хэмжээнд хуулийг тайлбарлан хэрэглэж буй байдал, шийдвэрлэж буй хэргийн онцлогийг гаргахыг зорьжээ. Уг эмхэтгэл нь шүүхийн нээлттэй ил тод байдал, олон нийтийн хяналт, хууль хэрэглээний нэгдмэл чанарыг хангах, үндэсний эрх зүйг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулах болно.

67.71

М 692

ХЗС 21801-21802

ЦЭРГИЙН ШИНЖЛЭХ УХААН

Паламдорж Ш. **Асуудал, шийдэл, арга зам:** Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл / Хян. Ц.Дашзэвэг; Хэвлийн эх бэлт. Т.Энхтунгалаг; Диз. Б.Эрдэнэбулган.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 320х.- (Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн).- ISBN: 978-9919-9597-4-6.



Уг бүтээлд эрдэмтэн Ш.Паламдоржийн сүүлийн таван жил (2015-2020 он)-д нийтлүүлсэн өгүүлэл болон эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэлүүдийг эмхтгэн гаргажээ. Үүнд: Аюулгүй байдал, батлан хамгаалах, цэргийн ухаанаар өнөө үед тулгамдаад байгаа асуудлыг нээн илрүүлэх, түүнийг шийдэх арга замын шинжлэх ухааны үндэслэлийг тайлбарласан болно.

68.4(1)

П 136

/НХУУТ-7/

ЭШФ Т 24221-24223

БОЛОВСРОЛ. СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ УХААН



Дэлгэржав М. **Багшийн мэргэжил дээшлүүлэх асуудал:** Судалгааны тойм / Ред. Н.Бэгз, Б.Жадамба, Р.Батринчин; Эх бэлт. Б.Болор; Хавтасны диз. Б.Эрдэнэбулган.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 224х.- ISBN: 978-9919-20-167-8.

Энэхүү бүтээл нь багш нарын мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаа, багшийн хөгжлийн үүсэл хөгжил, төрийн бодлого, эрх зүйн болон судалгааны хүрээнд өргөн зураглалаар авч үзэхийн зэрэгцээ техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нарын мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг судлан, шинжлэх ухааны болон эрх зүйн үндэслэлийг эрэлхийлж байгаагаар онцлогтой.

74.56(1)

Д 881

/НХУУТ-7/

ЭШФ Б 30145-30147



Жилээ Ж. **Сургалтын хөтөлбөрийн харьцуулсан судалгаа:** Нэг сэдэвт бүтээл / Ред. Б.Баасансүх, А.Санжмятав, А.Адьяасүрэн; Эрдэм шинжилгээний ред. Н.Бэгз, Б.Жадамба, Г.Уртнасан; Эх бэлт. Ч.Самбууням; Хавтасны диз. Б.Эрдэнэбулган.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 184х.- ISBN: 978-9919-9526-8-6.

Энэхүү судалгааны ажил нь МУБИС-ийн болон БНХАУ-ын ӨМБИС-ийн График дизайн мэргэжлийн бакалаврын сургалтын хөтөлбөрүүдийн үзэл баримтлал, бүтэц, дизайн тэдгээрийн онцлог шинж, ижил ба ялгаатай тал, давуу ба сул талыг судлах зорилгыг агуулсан.

74.58

Ж 70

/НХУУТ-7/

ЭШФ Б 30148-30150

СЭТГҮҮЛ ЗҮЙ

Баасансүрэн Т. **Монголын чөлөөт хэвлэл ба сэтгүүл зүйн шүүмж судлал, тулгамдсан зарим асуудал:** / Хян. М.Зулькафиль, С.Лочин, Л.Норовсүрэн; Эх бэлт. Ц.Чагнаадорж, Ч.Сувд; Диз. П.Содбаатар.- УБ.: Мөнхийн үсэг, 2020.- 512х.- ISBN: 978-9919-20-369-6.

Тус бүтээлийн эмхэтгэлд Монголд чөлөөт хэвлэл жинхэнэ утгаараа бүрэлдэн төлөвшиж хөгжсөн нь, монголын сэтгүүл зүйн шүүмж судлалын өсөлт хөгжилт, нэгэн телевизийн нэвтрүүлэг, хөтөлбөрт хийсэн ажиглалт судалгаа, Сономбалжирын Буяаннэмэхийн уран бүтээл, бичлэгийн арга барил, сэтгэлгээний онцлогт хийсэн ажиглалт шинжилгээ, “Зааг”-ийг задлахуй, “Дуудлага”-ыг дурдахуй - Жүмпэрэлийн Саруулбуянгийн нийтлэл, түүний ялгарах онцлог, “Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь” цувралыг бүтээх явцад уншиж ашигласан, иш гэрч татсан ном зохиол, бусад материал, зохиогчийн уран бүтээл, эрдэм шинжилгээний бүтээлүүдийн лавлах зэрэг зохиолч, сэтгүүлч Т.Баасансүрэнгийн шүүмж судалгааны бүтээлүүд багтжээ.

76.01


Б 109

Дэвт.7 (I хэсэг).- 512х.

Дэвт.7 (II хэсэг).- 485х.

ЭШФ Б 30114

ЭШФ Б 30113



ХЭЛ БИЧГИЙН ШИНЖЛЭХ УХААН

Бадамдорж Д. **Монгол хэлний гурвал тогтолцоо** / Хян. Л.Чулуунбаатар, А.Дэмбэрэлсүрэн.- УБ.: Удам соёл, 2020.- 116х.- (Монголын Үндэсний Их Сургууль, Олон улсын харилцааны сургууль).- ISBN: 978-9919-23-155-2.

Энэ бүтээлд орчин үеийн монгол хэл шинжлэлийн түвшин, салбарт хэл шинжлэлтэн нар монгол хэлний авиа зүй, авиалбарзүй, үсэгзүй, хэлбэр судлал, өгүүлбэрзүй, үгийн сан судлал, найруулга зүй, түүхэн хэлзүй, утга судлал, аялгуу судлал гэх зэрэг судалгаанд монгол хэлний гурвал бүрэлдүүлбэр байгааг бичсэн, монгол хэлний тогтолцооны өвөрмөц талыг дүгнэн монгол хүний сэтгэхүй, сэтгэлгээ, танин мэдэхүй, хэлний тогтолцооны гүн хамаарал байгааг онцлон харуулжээ.

81.2М

Б 153

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Б 30266-30268





Зайжөн Ү. **Орчин цагийн монгол хэлний үгзүй**: Монгол хэлний багц сурах бичиг / Ред. Б.Нэргүйжаргал, М.Азжаргал; Эх бэлт. Б.Үүрийнтуяа.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 290х.- ISBN: 978-9919-20-244-6.

Тус сурах бичиг нь нийт 12 бүлэг сэдвээс бүрдэх бөгөөд долоо хоногт нэг удаа хоёр цагаар, нэг улирлын туршид үзэж судлахад тохиромжтой. Бүлэг бүр дүрмийн тайлбар, жишээ, дасгалаас бүрдэнэ. Жишээ өгүүлбэрүүд гол төлөв монголын алдартай уран зохиолууд, сонины мэдээ зэргээс түүвэрлэсэн бөгөөд суралцагчид багшийн тусламжтай болон бие даан уншиж ойлгох боломжтой.

81.2М-96

3 16

/НХУУТ-3/

ЭШФ Т 23890-23891



Зээнямбуу Ч. ба бус. **Орос - Монгол толь = Русско-Монгольский словарь** / Ч.Зэгиймаа, К.Золбаяр; Ред. Ш.М.Николаевна, М.Базаррагчаа, Л.Одонтуяа; Диз. Т.Анбаяр.- УБ., 2020.- 784х.- ISBN: 978-9919-23-822-3.

Тус толь бичигт өргөн хэрэглээний үг, толгой үгийг цагаан толгойн дарааллаар байрлуулж хэлзүйн тайлбар, утгыг нь тодруулсан холбоо үг, хоршоо үг, төрөл бүрийн эхээс авсан жишээ өгүүлбэрийн орчуулгыг багтаажээ.

81.2Орос-4

3-973

/НХУУТ-7, ГНОФ-4/

ЭШФ Б 30269-30271



Хэл эзэмших онол арга зүй / Ерөн. ред. Д.Сайнбилэгт; Ред. Т.Ууганбаяр; Хян. Н.Мөнхцэцэг; Диз. М.Норжинсүрэн, Т.Тэмүүжин.- УБ.: МУИС пресс, 2020.- 471х.- ISBN: 978-9919504-28-1.

